

Чех улсын өдөр тутмын амьдралын нэгэн хэсэг ажил юм. Энэ хүрээнд бид ажилд явж, хөдөлмөр эрхэлж, хөдөлмөрийн харилцаатай, хөдөлмөрийн гэрээтэй гэсэн үг байна. Энэ нь юу гэсэн үг болохыг танд тайлбарлая.

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА нь хөдөлмөр гэрээ байгуулагдах болон ажилд орсон өдрөөс эхэлдэг.

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ - ажил олгогч болон тантай буюу ажилчин хоёрын хоорондох баримт бичиг бөгөөд үүндээр үндэслэн та өгөгдсөн ажил үүрэгээ гүйцэтгэнэ. Хөдөлмөрийн гэрээ нь бичгээр байх ёстой. Та болон ажил олгогч – хоёр тал гэрээний эх хувь дээр гарын үсэг зуран хүлээн авна.

Хөдөлмөрийн гэрээ юу агуулдаг:

- Таны хийх ажлын төрөл (ажлын байр).
- Ажилд орох өдөр.
- Таны ажлаа гүйцэтгэх газар.
 - Хэрэв та олон ажлын байр мэдэгдэж байгаа бол, жишээлбэл, бүх аймгуудад үйл ажиллагаа явуулах ба та компанийн машин ашиглах бол жолоочийн сургалтад тогтмол хамрагдах шаардлагатай бөгөөд үүндээр үндэслэн мэргэжлийн жолоочийн үр чадварын гэрчилгээ авна. Та үүнийг өөрийн биедээ авч явах хэрэгтэй.

! АНХААР ! ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНД ШААРДЛАГАТАЙ ЗҮЙЛС ДУТУУ БОЛ ХҮЧИНГҮЙ!

! АНХААР ! ОЙЛГОХГҮЙ ГЭРЭЭНДЭЭ ХЭЗЭЭ Ч ГАРЫН ҮСЭГ БҮҮ ЗУР. БҮХ БАРИМТ БИЧГЭЭ ХАДГАЛНА УУ.

Хөдөлмөрийн гэрээ нь ихэвчлэн дараах зүйлийг агуулна:

- **Гэрээ нь тодорхой хугацаатай Х хугацаагүй байна – гэрээ байгуулсан хугацаа.**
 - Тодорхой хугацаатай - хөдөлмөрийн гэрээнд ХЭЗЭЭС - ХЭЗЭЭ ХҮРТЭЛ хөдөлмөрийн харилцаа үргэлжлэхийг заасан байна. Та зөвхөн 3 удаа дараалан (хамгийн урт хугацаа нь 3 жил) хугацаатай гэрээ байгуулж болно. Үүний дараа та хугацаагүй гэрээтэй байх ёстой. Гэхдээ онцгой зүйлүүд байна!
 - Тодорхой хугацаагүй - хөдөлмөрийн гэрээнд хөдөлмөрийн харилцааны үргэлжлэх хугацааг заагаагүй болно.

! АНХААР ! – ГАДААД ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНЫ ХУГАЦАА НЬ БНЧУ-Д ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮЧИН ХУГАЦАА НӨЛӨӨЛӨХ БОЛОМЖТОЙ!



- **Туршилтын хугацаа** – ихэвчлэн 3 сар үргэлжилнэ. Энэ бол тухайн ажил танд тохирох эсэхийг туршиж үзэх боломжтой үе юм. Энэ хугацаанд та болон таны ажил олгогч ямар ч шалтгаангүйгээр хөдөлмөрийн харилцаагаа цуцалж боломжтой. Хөдөлмөрийн харилцааг бичгээр цуцлах ёстой. Энэ хугацаанд та эхлэх цалин гэж нэрлэдэх цалин авах боломжтой бөгөөд энэ нь 3 сарын туршилтын хугацаа дууссаны дараа нэмэгдэнэ. Цалингийн хэмжээг өөрчлөх нь ихэвчлэн хөдөлмөрийн гэрээний нэмэлт бичигт тэмдэглэгдсэн байна.

! АНХААР ! ШАЛГАЛТТАЙ (СУРАЛЦАХАД ЗОРИУЛСАН) ГЭРЭЭГҮЙ АЖИЛ НЬ ХУУЛЬ БУС!

- **Цалин** – хөдөлмөрийн гэрээнд нийт цалин гэж мэдэгдсэн байна. Үүнээс орлогын албан татвар, эрүүл мэндийн даатгал болон нийгмийн даатгал зэргийг хасдаг. Чех улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хуулиар тогтоосон байдаг. Ажилласан хуанлийн сарын цалинг буцаан төлдөг ба ихэвчлэн сард нэг удаа.

! АНХААР ! ТАНЫ ОРЛОГО ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ЭСВЭЛ БАЙНГА ОРШИН СУУХ ХҮСЭЛ МӨН ТАНЫ ТЭТГЭВЭРТ (АХМАДЫН ТЭТГЭВЭРТ) НӨЛӨӨЛЖ БОЛНО.

- **Амралтын эрх** – хуанлийн жил дуусахаас өмнө өдөр эсвэл цагаар авч болно. Амралт авахыг ажил олгогчоос урьдчилан зөвшөөрсөн байх ёстой.
- **Ажлын цаг** – Чех улсад бүтэн цагаар ажиллах тохиолдолд долоо хоногт 40 цаг гэж тогтоосон байдаг. Хагас цагаар ажиллах тохиолдолд долоо хоногт ажиллах цаг багасдаг. Үүний зэрэгцээ цалин, амралт авах эрх эсвэл бусад тэтгэмжүүд багасан.

ХЭРВЭЭ ТА НӨХЦӨЛ БАЙДАЛДАА ИТГЭЛГҮЙ БАЙВАЛ ГАДААД ИРГЭДЭД ТУСЛАХ ТӨВӨӨС ЗӨВЛӨГӨӨ АВАХ НЬ ДЭЭР, БИД ТАНД ТУСЛАХДАА БАЯРТАЙ БАЙХ БОЛНО. УУЛЗАЛТЫН ЦАГАА УРЬДЧИЛАН ТОВЛООРОЙ.

